



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 8/100

Мандалговь

Газар эзэмшүүлэх хэмжээ өөрчлөх тухай

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйл 21.3.2 дах заалт, 2013 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын 21 дүгээр зүйлийн ХХ.1.43 дахь хэсэг, Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол улсын 2013 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын 21 дүгээр зүйлийн ХХ.1.43 дахь хэсэгт тусгагдсан "Газрын кадастрын мэдээллийн сан"-г солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд "Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол, өндөр тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх" ажил хэрэгжсэнтэй холбогдуулан хавсралтанд заасан 1 иргэнд 400 м.кв (0,04 га) газрыг эзэмшүүлсүгэй.

2. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан хавсралтанд заасан аймгийн Засаг даргын захирамжийн холбогдох хэсгийг мөн газар эзэмших гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3. Хавсралтанд заасан иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), мөн гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт, Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч (С.Бат-Оргил), аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Ц.МОНХБАТ

4822100240